



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын сэдэв: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан.

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т заасан бүрэн эрх, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан аудитын жилийн төлөвлөгөөг үндэслэн нийцлийн аудитыг хийлээ.

ГЭРЭЭЛЭГЧДИЙН 2022 ОНД ТАЙЛАГНАСАН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛААС БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ 2,541,802.68 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ХАСАЖ, 12,784,754.51 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛД ТООЦОЖ БАТАЛГААЖУУЛЛАА.

Аудитын тайланг хүргүүлсэн:

УИХ-ын Эдийн засгийн болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
Ашигт малтмал, газрын тосны газар



Улаанбаатар хот
2024 он



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

Аудитын зорилго ба хамарсан хүрээ:

Газрын тосны салбарт хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн бүртгэж тайлагнасан хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардал, батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил нь холбогдох хууль тогтоомж, БХГ-тэй нийцэж буй эсэхийг баталгаажуулж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ. Үүнд:

- Гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, БХГ-ний дагуу анхан шатны баримт, материалд үндэслэн хянаж хүлээн авсан эсэх;
- Холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж үнэн зөв дүгнэлт, тайлан ирүүлсэн эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх;

Аудитаар АМГТГ-аас 2022 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тайлан, дүгнэлтийн хүрээнд тухайн гэрээлэгчдийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт материалыг хамрууллаа.

БҮЛЭГ 1. АМГТГ НЬ ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ, БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/117 дугаар тушаалаар “Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчийн 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримтад үндэслэн Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл тооцооны журам, бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд хяналт, шалгалтыг хийж, УАГ-т тайлан, дүгнэлтийг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/6007 дугаар албан бичгээр ирүүлсэн.


АМГТГ нь 2022 онд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын 14 гэрээлэгчийн 16 гэрээт талбайн БХГ-ний ерөнхий мэдээлэл, үйл ажиллагаа явуулсан болон явуулаагүй шалтгаан, үндэслэлийг дурдаж, үүнээс 10 гэрээлэгчийн 12 талбайд 38,294,715.75 ам.долларын хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулснаас тухайн оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу үйл ажиллагаа явуулж өртөг нөхөгдөх зардлыг тайлагнаж ирүүлсэн 6 гэрээлэгчийн 8 талбайн анхан шатны баримтыг үндэслэн хяналт шалгалт хийж, дүгнэсэн байна.

Дүгнэлтэд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч нарын 2022 оны батлагдсан жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл 50-аас доош хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийг бодитой төлөвлөөгүй, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын ажлыг бүрэн хийгээгүй, хяналт хангалтгүй байгааг харуулж байна. /График 1-ээс харах/



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

График 1: Гэрээлэгчдийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл /хувиар/



АМГТГ нь хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулсан Түмэн-Ойл ХХК-ийн Баянтүмэн XVII талбай нь орон нутгийн ИТХ-аас дэмжигдээгүй, Капкорп Монголиа ХХК-ийн Онги V талбай нь түр зогсолт авсан зэрэг шалтгаантай гэрээлэгч нарын бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллыг бүрэн төлсөн эсэхийг хянаж, дүгнээгүй байна.

УУХҮС-ын А/127 дугаар тушаалаар газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг 2019 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл хугацаатай олгож, “Зон Хэн Юу Тиан” ХХК-ний Галба XI талбайн хайгуулын эхний 8 жилийн хугацаа дуусгавар болсон ч хөрөнгийн эх үүсвэргүй шалтгаанаар 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулахгүй, БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад 2022 онд УУХҮС-ын А/200 дугаар тушаалаар 1 жил 6 сарын хугацаатай, 2024 онд А/60 дугаар тушаалаар 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүртэлх хугацаагаар тус тус сунгасан нь төрийн байгууллагын ажлын уялдаа, шат шатны хяналтын тогтолцоо сул байгааг харуулж байна.

Хөрөнгийн эх үүсвэргүй шалтгаанаар хайгуулын ажил хийгээгүй Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбай болон Чайна голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбайг хяналт шалгалтад хамруулаагүй нь БХГ-ний 7 дугаар зүйлийн 7.2.3, 7.3.3 заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул тухайн жилд гүйцэтгээгүй хайгуулын ажлын доод хэмжээ болох Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбай 1,240,000.00 ам.доллар, Чайна голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбай 600,000.00 ам.доллар, нийт 1,840,000.00 ам.доллар буюу 6,338.1 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Мөн төлөвлөгөө, төсөв ирүүлээгүй Макс-Ойл ХХК-ийн Ар-булаг ХХIX талбай, шүүхийн маргаантай Шунхлай Энержи ХХК-ийн Сулинхээр ХХХIII, орон нутгийн эсэргүүцэлтэй Монголиа Гладвилл Увс Петролеум ХХК-ийн Увс I талбай, Шейман ХХК-ийн Нялга XVI талбайд төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдэл дүгнэлт байхгүй байна.

АМГТГ нь Смарт ойл ХХК-ийн ӨНЗ-ын тайланд тайлагнасан зардлыг туслан гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг анхдагч нотлох баримтыг үндэслэн хяналт хэрэгжүүлээгүй баталгаажуулсан байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, батлуулсан боловч хайгуулын ажил гүйцэтгээгүй, хөрөнгө оруулалт хийгээгүй зэрэг гэрээгээр хүлээсэн



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

үүргээ биелүүлээгүй 8 гэрээлэгчдэд арга хэмжээ авч ажилласан талаар тайлан дүгнэлтэд тусгаагүй нь АМГТГ гэрээлэгчийн хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээлэгчдэд эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон зөвлөгөө чиглэл өгөх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

БҮЛЭГ 2. ГЭРЭЭЛЭГЧ ӨНЗ-ЫН ТАЙЛАНДАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ҮНЭН ЗӨВ БҮРТГЭЖ, ТАЙЛАГНАХГҮЙ БАЙНА.

Тайлант жил хайгуулын үйл ажиллагаа явуулсан 6 гэрээлэгчийн 8 гэрээт талбайд нийт 29,530,485.67 ам.долларыг зарцуулахаар төлөвлөгөө, төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр ӨНЗ-д 15,125,043.39 ам.долларыг бүртгэж тайлагнаснаас БХГ-ний заалтад нийцээгүй 2,541,802.68 м.долларын зардлыг хасаж, 12,784,754.51 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцож баталгаажууллаа.

Хүснэгт 2. Гэрээлэгчийн 2022 оны баталгаажсан ӨНЗ

№	Гэрээлэгчийн нэр	Талбайн нэр	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын гүйцэтгэл	АМГТГ-ын дүгнэлтээр хассан	Аудитаар хасагдсан зардал		2022 оны баталгаажсан ӨНЗ
					Хассан	Нэмсэн	
1	Монголын алт /МАК/ ХХК	Төхөм X урд	1,370,608.93	3,718.86	3,904.80	53.55	1,366,757.68
2	Метан газ ресурс ХХК	Таван толгой XXXIII	3,479,002.83	1,058,256.61	878,781.10	119,086.00	2,719,307.73
3	Жи Өү Эйч ХХК	Номгон IX	6,090,215.31	258,081.06	355,494.76	82,374.25	5,817,094.80
4	Тахь ресурс ХХК	Богд IV талбай	469,832.20	94,011.12	108,959.09		360,873.11
5		Онги V талбай	484,225.85	246,964.96	242,900.35		241,325.50
6		T-1 талбай	689,668.31	294,150.60	271,108.43		418,559.88
7	Тэлмэн Ресурс ХХК	Гурвантэс XXXV	994,686.30	83,210.20	89,107.37		905,578.93
8	Смарт-ойл Монголиа ХХК	Эргэл XII	1,546,803.66	427,979.16	591,546.78		955,256.88
дүн			15,125,043.39	2,466,372.57	2,541,802.68	201,513.80	12,784,754.51

Метангаз ресурс ХХК-аас баганат өрөмдлөгийн ажлын төлөвлөгөө, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 113 дугаартай албан бичгээр хүргүүлсэн хэдий ч АМГТГ-аас газрын тосны бүртгэл, тооцооны журмын 7.4 -т заасан заалтыг үндэслэн шаардлагагүй гэж үзсэнээс тухайн хайгуулын зардал хэтэрсэн байна. Энэ нь БХГ-ний 7.3 дугаар зүйлийн 7.3.2 “гэрээлэгч нь шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагын зөвшөөрснөөр жилийн төсөв, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт оруулах төсөв, төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад ирүүлснээс хойш ажлын 15 (арван тав) хоногийн дотор батална” гэж заалттай нийцэхгүй байна.

Аудитаар дараа зөрчлийг ӨНЗ-аас хасаж тооцлоо. Үүнд:

- Хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээлэгчдийн ажлын гүйцэтгэл, ӨНЗ-д тайлагнасан ажлыг талбай тус бүрээр хянахад жилийн батлагдсан төлөвлөгөө, төсвийг **554,318.89** ам.доллороор хэтрүүлсэн, төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй **103,278.16** ам.долларын хөрөнгө худалдан авсан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу **346,686.36** ам.доллар, баримтын зөрчилтэй гэрээ байгуулсан **180,003.77** ам.долларын зардал тайлагнасан;
- Хайгуулын үйл ажиллагаа явуулсан талаарх анхдагч тайлан мэдээ, материалыг илгээгээгүй **441,981.46** ам.долларыг тайлагнасан;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

- Гэрээлэгч нь гадаад улсад **430,705.76** ам.долларын гүйлгээ хийж өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан;
- Гэрээлэгч түрээсийн урьдчилгаа дансны ажил гүйлгээнээс валютын ханшийн зөрүүтэй **504.22** ам.доллар илүү тайлагнасан;
- Захиргааны зардлын хувь хэмжээг **104,109.69** ам.долларын зөрүүтэй тайлагнаж ирүүлсэн;
- Гэрээлэгч өртөг нөхөх зардалд тооцогдохгүй **19,138.81** ам.долларын татвар, хураамж, тээврийн зардал бүртгэж тайлагнасан;
- Гэрээлэгч захиргааны ажилтнууд болон захиргааны үйл ажиллагаатай холбогдон гарсан **31,360.82** ам.долларын зардлыг ӨНЗ оруулан тооцсон;
- Гэрээлэгч 1984 онд Улсын төсвөөр хийгдсэн **22,475.00** ам.долларын ажлыг 2022 оны төлөвлөгөөнд баталж, гүйцэтгэлээр тайлагнасан;
- ХХҮЕГ-аас гадаадаас ажиллах хүчний зөвшөөрөл олгоогүй шалтгаанаар хийгдээгүй ажлын **300,000.00** ам.долларыг 2022 оны ӨНЗ-д оруулсан тайлагнасан;
- Нэмэлт тодотгол хийх хуулийн шаардлага үүсээгүй байхад **7,239.74** ам.долларын гэрээ байгуулсан. Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2.3.9-д "Хэрэгжиж байгаа төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл шинэчлэгдэх, өргөтгөл хийх (техник, технологийг шинэчлэх, түүхий эд, байгалийн нөөц баялгийг ашиглах хэмжээ, хүчин чадал, газрын байрлал өөрчлөх болон байгаль орчны аудитын зөвлөмжөөр нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай гэж үзсэн зэрэг) болон тухайн төсөлтэй холбогдох харилцааг зохицуулах эрх зүйн гол баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийнэ" заалтыг зөрчсөн байна.

Гэрээлэгчид Газрын тосны тухай хуулийн дагуу төлөх төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг хугацаандаа бүрэн төлж байршуулаагүй байна.

- Тахь ресурс ХХК-ийн орон нутгийг хөгжүүлэх урамшууллын зардлын Онги V талбай 20,000.00 ам.доллар, Богд IV талбай 15,000.00 ам.доллар нийт 35,000.00 ам.долларыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.
- Байгаль орчны баталгаа эскроу дансанд байршуулаагүй Монголын алт /МАК/ ХХК -ийн 149,175.00 ам.долларыг, Тахь ресурс ХХК-ийн дутуу байршуулсан 4,984.00 ам.долларыг тус тус нөхөж байршуулах албан шаардлага хүргүүлсэн.

БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Өмнөх оны аудитаар Монгол Улсын Ерөнхий сайд 1, Монгол Улсын Засгийн газар 1, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 6, Ашигт малтмал, газрын тосны газар 8, Гэрээлэгч нарт 7, нийт 23 зөвлөмж өгч, Ашигт малтмал, газрын тосны газар 3 төлбөрийн акт тогтоож, 6 албан шаардлага өгсөн байна.

Хүснэгт 3: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /ам.доллар/

Үзүүлэлт	Огноо	Аудитын шийдвэр						
		Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		зөрүү		
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	хувь
Төлбөрийн акт	2019-2020	1	4,799,703.00	0	533,979.70	1	4,265,723.30	
	2021	2	2,631,374.00	0	-	2	2,631,374.00	
Дүн		3	7,431,077.00	0	533,979.70	3	6,897,097.30	0%
	2019-2020	5		3		2	-	



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

Албан шаардлага	2021	1		1		0	-	
Дүн		6	-	4	-	2	-	67%
Зөвлөмж	2019-2020	12		5		7	-	
	2021	11		4		7	-	
Дүн		23	-	9	-	14	-	39%
Нийт дүн		32	7,431,077.00	13	533,979.70	19	6,897,097.30	41%

Аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлт 0 хувь, албан шаардлагын биелэлт 67 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 39 хувьтай нийт хэрэгжилт 41 хувьтай байна.

Өмнөх аудитаар тогтоосон дараах төлбөрийн акт барагдаагүй байна. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газарт 4,799,703.00 ам.долларын 1 төлбөрийн актыг тогтоосноос 533,979.70 ам.долларыг барагдуулж, Шунхлай энерги ХХК-ийн 1,511,830.70 ам.доллар, Макс ойл ХХК-ийн 2,753,892.80 ам.долларын төлбөрийг барагдуулаагүй байна.
- 2020-2021 онуудад нийт 1,612,199.00 ам.долларын тусгай зөвшөөрлийн төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэгийг төлөөгүй зөрчилд тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй байна. /Макс ойл ХХК-ийн Арбулаг ХХИХ талбай 782,267.00 ам.доллар, Монголын алт ХХК-ийн Төхөм-Х урд талбай 681,389.00 ам.доллар, Петроматад ХХК-ийн Матад ХХ талбай 18,377.00 ам.доллар, Петровис ресурс ХХК-ийн Богд IV, Онги 5, Т-1 талбайнууд 123,008.00 ам.доллар, Метан газ ресурс ХХК-ийн Тавантолгой ХХХIII талбай 7,158.00 ам.доллар/
- Хайгуулын ажлын доод хэмжээг дутуу гүйцэтгэсэн Метангаз ресурс ХХК-ийн 517,230.00 ам.доллар, Жи Өү эйч ХХК-ийн 154,410.00 ам.доллар, Тэлмэн ресурс ХХК-ийн 347,535.00 ам.доллар нийт 1,019,175.00 ам.долларын төлбөр төлөөгүй асуудлаар Нийслэл дэх Захиргааны шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Өмнөх аудитаар 6 албан шаардлага өгснөөс 2 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газраас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучнаар/-д 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 1/2500 тоот албан бичгээр хандсан боловч зөрчлийн хуулиар арга хэмжээ авсан тухай биелэлт ирээгүй;
- Санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, МУ-ын хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэрээлэгчдийг 2023 оны 05 дугаар сарын 29-ний 1/2694 албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжүүдийг өгсөн.

1. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн 2022 онд холбогдох хууль тогтоомж, Бүтээгдэхүүн хуваах гэрээг зөрчиж тайлагнасан 2,541,802.68 ам.долларын өртөг нөхөгдөх зардлыг аудитаар хасаж тооцон, нийт 12,784,754.51 ам.доллараар баталгаажууллаа.
2. АМГТГ-нь гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд тавих хяналт, гэрээлэгчдэд эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон зөвлөгөө чиглэл өгөх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
3. Төрөөс гэрээлэгчдэд хайгуулын талбайд хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгосон боловч хайгуулын талбайд ажил гүйцэтгэхэд орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарах, орон нутгийн удирдлагаас үйл ажиллагааг нь дэмжихгүй зэрэг гэрээлэгчээс хамааралгүйгээр БХГ-ээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болох эрсдэл үүссэн байна.
4. Ашигт малтмал газрын тосны газар нь холбогдох хяналт, шалгалтын дүгнэлт, тайланг 1 жилийн хугацаа хоцролттой ирүүлж байгаагаас аудитаар баталгаажуулах өртөг нөхөгдөх зардалтай холбоотой тоо, мэдээллийг гэрээлэгчдийн дараагийн санхүүгийн тайлантай уялдуулан залруулга хийлгэх боломжгүй нөхцөл үүсэж байна.
5. Өмнөх аудитаар газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагуудын эрх бүхий албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:

1. Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, санал боловсруулж шийдвэрлэх;
2. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үйл ажиллагаа явуулаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрх, үүргээ биелүүлэхгүй байгаад анхаарч, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах;
2. Батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу ажил хийгдээгүй шалтгаан, анхаарал татахуйц гүйцэтгэлийн нөхцөл байдлын талаар хяналт, шалгалтын тайлан дүгнэлтэд тайлагнаж ирүүлэх;
3. Гэрээлэгч болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдаа, хариуцлага, хяналтыг сайжруулж, өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах;
4. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд:

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, баталгаажуулсан ӨНЗ-ын дүнг санхүүгийн тайлан болон ӨНЗ-ын тайланд залруулж, бүртгэх;
2. Хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчид бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлэх;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хураангуй тайлан

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

№	Аудитад хамрагдсан байгууллага	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /ам.доллар/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдэл
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, санал боловсруулж шийдвэрлэх		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
3	Ашигт малтмал, газрын тосны газар	Гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй байна.	1,840,000.00	Төлбөрийн акт тогтоосон		Төлбөрийн акт тогтоосон
4	Ашигт малтмал, газрын тосны газар	Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал дэмжлэг төвлөрүүлээгүй байна	35,000.00	Төлбөрийн акт тогтоосон		Төлбөрийн акт тогтоосон
5	Ашигт малтмал, газрын тосны газар	Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байгаль орчныг нөхөн сэргээх төлбөр байршуулаагүй байна.	154,159.00	Албан шаардлага өгсөн		Албан шаардлага өгсөн
6	Ашигт малтмал, газрын тосны газар	Бүтээгдэхүүн хуваах гэрээний үйл ажиллагаа явуулаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрх, үүргээ биелүүлэхгүй байгаад анхаарч, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах;		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
7	Ашигт малтмал, газрын тосны газар	Батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу ажил хийгдээгүй шалтгаан, анхаарал татахуйц гүйцэтгэлийн нөхцөл байдлын талаар хяналт, шалгалтын тайлан дүгнэлтэд тайлагнаж ирүүлэх;		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
8	Ашигт малтмал, газрын тосны газар	Гэрээлэгч болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдаа, хариуцлага, хяналтыг сайжруулж, өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах;		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
9	Ашигт малтмал, газрын тосны газар	Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
10	Гэрээлэгчид	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, баталгаажуулсан ӨНЗ-ын дүнг санхүүгийн тайлан болон ӨНЗ-ын тайланд залруулж, бүртгэх;		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
11	Гэрээлэгчид	Хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчид бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлэх;		Зөвлөмж өгсөн		Зөвлөмж өгсөн
Дүн			2,029,159.00			